



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/523

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Цэвэр усны даралтат цамхаг барих 2-р шатны (Хангал сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан "Тэнгэрхишиг" ХХК-тай 234,000,000 (хоёр зуун гучин дөрвөн сая) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Тэнгэрхишиг" ХХК-ийн захирал (Ж.Амаржаргал)-д үүрэг болгосугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6313010535

Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 20-ны өдрийн
А/523 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	4 411 570	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техникийн хяналтын зардал	4 411 570	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	2 205 785	Ү.Бямбасүрэн
5.	Алданги	Хоногт гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,1 хувь байна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас ихгүй байна.	Д.Батцогт
6.	Ажил гүйцэтгэх хугацаа	50 хоног	Ү.Бямбасүрэн
7.	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.	Д.Батцогт
8.	Орон нутгаас авч ажиллах иргэдийн тоо	3 хүн	Н.Батжаргал